



МОНГОЛ УЛС
СҮХБААТАР АЙМГИЙН ЗАСАГ
ДАРГЫН ЗАХИРАМЖ

2022 оны 02 сарын 15 өдөр

Дугаар А/87

Баруун-Урт сум

Тендерийн үнэлгээний хороо байгуулах
тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль”-ийн 46 дугаар зүйлийн 46.1.1, 47 дугаар зүйлийн 47.1 дэх заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. 2022 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн А/74 дүгээр захирамжаар батлагдсан Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний дагуу Наран суманд хийгдэх замын зураг төслийн цар хүрээ, нэршил өөрчлөгдөж “Сумын төвийн хатуу хучилттай автозамын зураг төсөл төсөв боловсруулах (Наран сум)” зөвлөх үйлчилгээ болсон тул үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Дарга:	Г.Мөнхзаяа	- Аймгийн Засаг даргын орлогч
Гишүүд:	Ц.Алтансүх	- Орон нутгийн өмчийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч
	Б.Алтансүх	- Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын Барилгын хэлтсийн дарга
	Э.Батзаяа	- Иргэний нийгмийн байгууллагын төлөөлөл
Нарийн бичгийн дарга:	С.Баярмаа	- Орон нутгийн өмчийн газрын мэргэжилтэн

2. Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийн үйл ажиллагааг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж ажиллахыг үнэлгээний хороо (Г.Мөнхзаяа)-д үүрэг болгосугай.

3. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан “Сумын төвийн 2 км хайрган хучилттай автозамын зураг төсөл боловсруулах (Наран сум)” зөвлөх үйлчилгээний үнэлгээний хороо байгуулсан 2022 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн А/20 дугаар захирамжийг хүчингүй болгосугай.

ЗАСАГ ДАРГА

A red rectangular official stamp is centered on the page. Overlaid on the stamp is a handwritten signature in black ink, which appears to be 'М. ИДЭРБАТ'. The signature is written in a cursive style.

М.ИДЭРБАТ